

АУДИТЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1.Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газраас гэрээгээр 2017 оны төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй ҮАГ-ын зөвлөх үйлчилгээний хураангуй жагсаалтад орсон аудитын хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2.“Санхүүгийн тайланд гэрээгээр аудит хийж гүйцэтгэх ажил”-ыг 2018 оны 1 сарын 1-нээс 03 дугаар сарын 30-ны дотор гүйцэтгэнэ.

3.Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх үйлчилгээ үзүүлэх хараат бус аудитын хуулийн этгээд нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээлэл /нотлох баримт/-ийн хамт ирүүлнэ үү. Үүнд:

- Улсын бүртгэлийн гэрчилгээ, аудит хийх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь тухайн жилд аудит хийх хуулийн цаглабар хугацаатай нийцсэн эсэх /Тендерийн явцад тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахаар эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байгаа тохиолдолд тухайн байгууллагаас лавлагаа авсан байх/,
- Аудитын компаний захирал нь мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс зохих зөвшөөрөлтэй байх,
- Аудитын хуулийн этгээд нь 2-оос доошгүй үндсэн орон тооны, хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчтой байх,
- Аудитын компаний захирал болон мэргэшсэн нягтлан бодогчид нь мэргэжлийн ёс зүйн алдаа гаргаагүй талаар ММНБИ-ийн тодорхойлолттой байх
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчөөгүй байх,
- Аудиторууд нь аудитын ажил хийж гүйцэтгэсэн 2-оос доошгүй жилийн туршлагатай байх, хэрэв ийм ажил гүйцэтгээгүй бол мөн хугацаанд улсын салбарт ижил төстэй ажил хийсэн туршлагатай байх.
- Сангийн яам болон бусад мэргэжлийн байгууллагаас хийгдсэн чанарын баталгаажуулалтын дүгнэлт

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

4.Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017 оны 11 сарын 29-ны өдрийн 09.00 цагаас эхлэн ажлын өдөр 09.00-18.00 цагийн хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 18 цаг 00 минутын дотор ирүүлнэ үү.

Өвөрхангай аймгийн Засаг Даргын Тамгын газрын 4-р давхарт

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газар

Утас:70323833, 70323108